



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/524

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.5, 6.6 дэх хэсэг, аймгийн онцгой комиссын 2026 оны 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өлгий, Ховд аймагт малын гоц халдварт шүлхий өвчин (SAT-1) бүртгэгдэж, тархалтын хүрээ нэмэгдэж байгаа тул урьдчилан сэргийлэх, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сумдыг удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг хавсралтаар зохион байгуулсугай.

2.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, малчдад ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах 2.730.000 (хоёр сая долоон зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Насанбат)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 04-ны өдрийн 14 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

БУГАТ СУМД АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батдорж (Онцгой байдлын газрын гамшгаас
хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал
хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч)
Гишүүд: Ч.Эрэхмбаяр (Мал эмнэлгийн газрын лабораторын
эрхлэгч)

ТОНХИЛ, ДАРИВ СУМДАД АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Баттүвшин (Онцгой байдлын газрын орлогч,
урьдчилан сэргийлэх тасгийн дарга,
гамшгаас хамгаалах улсын хяналтын
ахлах байцаагч, дэд хурандаа)
Гишүүд: А.Лхамгарьд (Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн)
Жолооч: З.Алтанзул (Онцгой байдлын газрын эрэн хайх,
аврах салбарын аврагч, жолооч,
холбоочин, ахлах ахлагч)

ХӨХМОРЬТ СУМД АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Э.Баттөр (Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай
аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга,
дэд хурандаа)
Гишүүд: Д.Бүжинлхам (Мал эмнэлгийн газрын лабораторын
эмч)

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 04 -ны өдрийн 4/2 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЕХНИК ХЭРЭГСЭЛ

Д/д	Марк	Улсын дугаар	Явах км	Шатахуун
1	Уаз хантер	01-05 ГАЕ	1250	АЙ-92
2	Ниссан патрол	96-52ГАУ	850	ДТ
3	Ланд крузер-200	02-00 ГАО	850	АИ-92

_ оОо _